



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2021. 08. 04 № 28

Асуулт тавих тухай

"Монгол ураниум ресурс" ХХК-ийн үйл ажиллагааны улмаас Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хамаарах Хулстай, Эрээн, Тохой, Хонгор, Цагаан эргийн голын усны ундарга багасч, эх нь ширгэх аюул нүүрлээд байна.

Түүнчлэн тус компани олборлолт явуулж байхдаа усны судлыг гэмтээсний улмаас одоог хүртэл ус сул асгарч, арга хэмжээ авахгүй байгаа талаар нутгийн иргэд мэдээлэл ирүүлсээр байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т заасныг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. "Монгол ураниум ресурс" ХХК Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалт /ашиглах усны эх үүсвэр, эсхүл рашааны эх булаг, түүний байршлыг харуулсан зураг;/ 28.2.3 дахь заалт /хоногт ашиглах усны хэмжээ, зориулалт;/, 28.2.6 дахь заалт /байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт./-т заасан баримт бичгийг тус тус бүрдүүлэн, мөн хуулийн 28.4 дэх хэсэгт заасан этгээдэд ус ашиглах хүсэлт гаргасан эсэх талаар;

2. Тус компани Усны тухай хуулийн 29.1 дэх хэсэг /Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна./-т заасны дагуу "Ус ашиглах гэрээ" байгуулсан эсэх талаар;

3. Ус ашиглах гэрээний дагуу Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5 дахь заалт /ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ;/ 29.2.6 дахь заалт /хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ;/-д заасан төлбөрийг төлж байгаа эсэх талаарх мэдээлэл бэлтгэж ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд бэлтгэж ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

НАЯНТАЙН ГАНИБАЛ

2020000199